

“СҮҮ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03-р сарын 18-ны өдөр

№ 07

Улаанбаатар хот

“ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ”

Компанийн тухай хуулийн 46.15, 60.1, 60.2, 76.1, 80.2 дахь хэсгүүд болон “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ыг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 15:00 цагт, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-24 хаягт орших, “Холидэй Инн” зочид буудлын хурлын танхимд цахим хэлбэрээр зохион байгуулж, хурлыг компанийн албан ёсны <https://www.facebook.com/mongolmilk.mn/> фэйсбүүк хуудсаар дамжуулан, олон нийтэд нээлттэй хүргэсүгэй.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

- Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал,
- “Сүү” ХК-ийн охин компани болох “Макс Агро” ХХК-ийг “Сүү” ХК-тай нэгтгэх тухай асуудал,
- “Сүү” ХК-ийн 2020 он, 2021 оны эхний хагас жилийн ногдол ашиг тараалтын тайлан болон 2021 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг тараах талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх,

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөр тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн Өнөөдөр сонин, “MNC” телевизийн эфир, компанийн болон “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд мэдээлсүгэй. Хурлын зарыг олон нийтэд анх мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээллэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг www.survey.suu.mn цахим хуудсаар дамжуулан, 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийг дуустал хугацаанд бүртгэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал хураалтыг цахим хэлбэрээр явуулах, хуралд оролцогчийг системд бүртгэх, түүний саналыг авах, ирцийн мэдээ болон авсан саналын дүнг өөрчлөх боломжгүйгээр, үнэн зөв илэрхийлэх боломжтой программ хангамж бүхий, зохих ажлын туршлагатай мэдээллийн технологийн компанитай үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал /М.Болод/-д даалгасугай.

7. “Сүү” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д оролцох Хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийн жагсаалтыг Хавсралт №1 ёсоор, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын дэгийг Хавсралт №2 ёсоор, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын зарын төслийг Хавсралт №3 ёсоор, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын санал авах хуудасны загварыг Хавсралт №4 ёсоор, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын тооллогын комиссын тогтоолын төслийг

Хавсралт №5 ёсоор, "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал"-аас гарах шийдвэрийн төслийг Хавсралт №6 ёсоор тус тус баталсугай.

8. "Сүү" ХК-ийн "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал"-ийн саналын хуудсыг цахимаар болон шуудангаар хүлээн авах бөгөөд саналын хуудас шуудангаар хүлээн авах сүүлчийн хугацааг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөр, цахимаар хүлээн авах сүүлийн хугацааг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр хуралдах хурлын саналын хуудас хүлээн авах сүүлийн хугацаагаар тус тус тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдэд холбогдох баримт бичигтэй тус компанийн www.suu.mn цахим хуудсанд хандан танилцаж болохыг мэдэгдсүгэй.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын болон хурал зохион байгуулах комиссын даргаар ТУЗ-ийн гишүүн Ц.Соёл-Эрдэнийг, хурал зохион байгуулах комиссын гишүүнээр Г.Баярбаатар, Б.Энхжаргал нарыг томилсугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын даргаар Т.Дамдинсүрэн, гишүүнээр Ц.Бор-Охин нарыг тус тус томилсугай.

12. Тооллогын комисс Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3 дахь хэсгийг удирдлага болгон ажилласугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Д.ГАНБААТАР

“Сүү” ХК-ийн ТУЗ-ийн
2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
№07 тоот Тогтоолын хавсралт-№1



**“СҮҮ” ХК-ИЙН “ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ”-Д ОРОЛЦОХ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДЭД ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧИГ**

“Сүү” ХК-ийн 2022 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ыг зарлан хуралдуулахтай холбогдуулан тус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд Компанийн тухай хуульд заасан болон дараах баримт бичгийг танилцуулна. Үүнд:

○ “Сүү” ХК-ийн ТУЗ-ийн 2022.03.18-ны өдрийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай” тогтоол болон тогтоолын хавсралтууд:

- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг,
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар,
- ✓ “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-аар хэлэлцэх асуудлаар санал авах хуудасны загвар,
- ✓ Тооллогын комиссын тогтоолын төслүүд,
- ✓ “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-аас гарах шийдвэрийн төслүүд:
 - Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай,
 - “Сүү” ХК-ийн охин компани болох “Макс Агро” ХХК-ийг “Сүү” ХК-тай нэгтгэх тухай асуудал,

-----oOo-----

2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
№07 тоот Тогтоолын хавсралт №2



**2022 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДӨР ХУРАЛДАХ “СҮҮ” ХК-ИЙН
“ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ”-ЫН ДЭГ**

1. Хурлын ирц бүртгэх, /10 минут/
2. Хурлын ирц мэдээлэх, /1 минут/
3. Хурлыг нээлт, /5 минут/
4. Хэлэлцэх асуудал №1: Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал, /30-40 минут/,
5. Хэлэлцэх асуудал №2: “Сүү” ХК-ийн охин компани болох “Макс Агро” ХХК-ийг “Сүү” ХК-тай нэгтгэх тухай асуудал, /15 минут/,
6. Хэлэлцэх асуудал №3: “Сүү” ХК-ийн 2020 он, 2021 оны эхний хагас жилийн ногдол ашиг тараалтын тайлан болон 2021 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг тараах талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх тухай асуудал, /5 минут/,
7. Хувьцаа эзэмшигчдээс цахим хэлбэрээр асуулт хүлээн авах, /10 минут/,
8. Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуултад хариулах, /10-15 минут/,
8. Хувьцаа эзэмшигчдээс саналын хуудас хүлээн авах, /20 минут/,
9. Хурлын завсарлага /10-15 минут/
10. Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах, /3 минут/
11. Хурлыг хаах /5 минут/

-----oOo-----

“Сүү” ХК-ийн ТУЗ-ийн
2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
№07 тоот Тогтоолын хавсралт №3



“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Сүү” ХК-ийн 2022 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ыг 2022 оны 04 сарын 29-ний өдрийн 15:00 цагт компанийн албан ёсны <https://www.facebook.com/mongolmilk.mn/> цахим хуудсаар дамжуулан, олон нийтэд нээлттэй явуулна.

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

- Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал,
- “Сүү” ХК-ийн охин компани болох “Макс Агро” ХХК-ийг “Сүү” ХК-тай нэгтгэх тухай асуудал,
- “Сүү” ХК-ийн 2020 он, 2021 оны эхний хагас жилийн ногдол ашиг тараалтын тайлан болон 2021 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг тараах талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх,

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдөр нь 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр байна.

Хувьцаа эзэмшигч Та бүхэн хуралд оролцохын тулд www.survey.suu.mn цахим хуудсаар дамжуулан, 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийг дуустал хугацаанд бүртгүүлнэ.

“Сүү” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ийн саналын хуудсыг цахимаар болон шуудангаар хүлээн авах бөгөөд саналын хуудас шуудангаар хүлээн авах сүүлийн хугацааг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөр, цахимаар хүлээн авах сүүлийн хугацааг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр хуралдах хурлын саналын хуудас хүлээн авах сүүлийн хугацаагаар тус тус тогтооно.

Хувьцаа эзэмшигч нь хурлын материалтай тус компанийн www.suu.mn цахим хуудсанд хандан танилцах эсвэл өөрийн харилцагч Үнэт цаасны компаниар дамжуулан танилцах боломжтой.

Нэмэлт мэдээлэл:

Хувьцаа эзэмшигч хурлын үеэр санал хэлж, асуулт асуухдаа компанийн албан ёсны <https://www.facebook.com/mongolmilk.mn/> цахим хуудсанд мессэж бичих, эсвэл info@mongolmilk.mn цахим хаягт имэйл илгээх боломжтой бөгөөд ийнхүү мессэж бичих, имэйл илгээхдээ хувьцаа эзэмшигч өөрийн овог, нэр, регистрийн дугаарыг үнэн зөв бичсэн байх ёстойг анхаарна уу.

Харилцах утас: 88062481 /Г.Баярбаатар/
Шуудангийн хаяг: Bayarbaatar.g@mongolmilk.mn

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС



“Сүү” ХК-ийн ТУЗ-ийн
2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
№07 тоот Тогтоолын хавсралт №4

**“СҮҮ” ХК-ИЙН “ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛ”-Д САНАЛ АВАХ ХУУДАС**

Энэхүү санал авах хуудсаар 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-24 хаягт орших, “Холидэй Инн” зочид буудлын хурлын танхимд цахим хэлбэрээр хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

Хувьцаа эзэмшигчийн овог:нэр.....

Регистрийн дугаар:

Санал өгөх хувьцааны тоо:

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн,

№	Санал өгөх асуудлын агуулга	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай			
2	“Сүү” ХК-ийн охин компани болох “Макс Агро” ХХК-ийг “Сүү” ХК-тай нэгтгэх тухай асуудал,			

Санал авах хуудсыг ашиглах санамж:

1. Та санал авах хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓,+ эсвэл **санал өгч буй хувьцааны тоо ширхэгийн** тэмдэглэгээг хийнэ үү.
2. Санал авах хуудсыг засварласан, балласан тохиолдолд санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
3. Хувьцаа эзэмшигч нь хэлэлцэж буй асуудалд саналаа өгөхдөө санал авах хуудсыг бөглөн доорх хаягаар шуудангаар ирүүлж болохоос гадна, хурал болох өдөр цахим хэлбэрээр саналаа өгч болно.
4. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч, итгэмжлэлийг нотариатаар гэрчлүүлсэн байна.
5. Шуудангийн хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо, Үйлдвэрчний эвлэлийн гудамж-37, 2077108 ш/х-27

Санал өгсөн хувьцаа эзэмшигч: /Гарын үсэг/

Брокер /ҮЦК-аар дамжуулан санал өгсөн бол/: /Гарын үсэг, тэмдэг/

Санал өгсөн огноо: 2022 оны сарын өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон:

Тооллогын комиссын дарга: /...../

Санал авах хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан:

.....



2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
№07 тоот Тогтоолын хавсралт №5

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2022 оны 04-р сарын 29-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

ХУРЛЫН ИРЦИЙН ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3 дахь хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын ирцийг хурлын даргад МЭДЭЭЛЭХ нь:

1. “Сүү” ХК-ийн 2022 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр байсныг дурдсугай.

2. Бүртгэлийн өдрөөр “Сүү” ХК-ийн нийт саналын эрхтэй хувьцааны тоо ширхэг байснаас 2022 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д саналын эрхтэй, нийт хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирснээр хурлын ирц% болж, хурлын ирц бүрдсэнийг мэдэгдсүгэй.

Тооллогын комиссын

дарга:

Гишүүд:

.....

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2022 оны 04-р сарын 29-ний өдөр

№ 02

Улаанбаатар хот

САНАЛ ХУРААЛТЫН НЭГДСЭН ДҮНГИЙН ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3 дахь хэсэг, “Сүү” ХК-ийн 2022 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д санал хураалтаар хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн санал хураах хуудсыг тоолсон тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Сүү” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон саналын эрхтэй нийт ширхэг хувьцааны% буюу ширхэг хувьцаа эзэмшиж буй хувьцаа эзэмшигч саналын хуудсаар саналаа ирүүлснээс ширхэг хувьцаа эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүчин төгөлдөрт тооцсугай.

2. Ердийн журмаар санал өгөх хувьцааны тоог ширхэгээр тогтоосугай.

3. Саналын хуудсаар “Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай” асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн % зөвшөөрсөн, % татгалзсан, % түтгэлзсэн байгааг мэдэгдсүгэй.

1. Зөвшөөрсөн		2. Татгалзсан		3. Түтгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
.....%%%

4. Саналын хуудсаар “Сүү” ХК-ийн охин компани болох “Макс Агро” ХХК-ийг “Сүү” ХК-тай нэгтгэх тухай” асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн % зөвшөөрсөн, % татгалзсан,% түтгэлзсэн байгааг мэдэгдсүгэй.

1. Зөвшөөрсөн		2. Татгалзсан		3. Түтгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
.....%%%

Тооллогын комиссын
дарга:

Гишүүд:

..... /

..... /

..... /

“Сүү” ХК-ийн ТУЗ-ийн
2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
№07 тоот Тогтоолын хавсралт-№6



“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04-р сарын 29-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн №02 тоот “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

3. “Сүү” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04-р сарын 29-ний өдөр

№ 02

Улаанбаатар хот

“МАКС АГРО” ХХК-ИЙГ НЭГТГЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.2 дахь хэсэг, “Сүү” ХК-ийн дүрмийн 5 дугаар бүлэг болон “Сүү” ХК-ийн 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн №02 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Макс Агро” ХХК-ийг “Сүү” ХК-тай нэгтгэх замаар компанийг өөрчлөн байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрсүгэй.
2. Нэгтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор компани хооронд нэгтгэх гэрээг нэгдүгээр хавсралтаар, нэгтгэх журмыг хоёрдугаар хавсралтаар баталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Д.Ганбаатар /-д даалгасугай.
3. Нэгтгэх үйл ажиллагаатай холбоотойгоор Улсын бүртгэлийн газар болон Татвар, санхүүгийн холбогдох байгууллагад бүртгүүлэх болон холбогдох бусад арга хэмжээ авах ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Д.Ганбаатар/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ

**КОМПАНИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГЫГ
ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ**

20... оны ... сарын

№

Улаанбаатар хот

Нэг талаас: “Сүү” ХК (цаашид “А” тал гэх)

Нөгөө талаас “Макс Агро” ХХК (цаашид “Б” тал гэх)

бид “СҮҮ” ХК-ийн 20... оны ... дүгээр сарын ...-ны өдрийн тоот Хувьцаа эзэмшигчийн Шийдвэр, “Макс Агро” ХХК-ийн 20... оны ... дүгээр сарын ...-ны өдрийн тоот Хувьцаа эзэмшигчийн Шийдвэрийг тус тус үндэслэн дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Гэрээний гол нөхцөл

- 1.1 “Б” талыг “А” талд нэгтгэх Хувьцаа эзэмшигчийн Шийдвэр гарсантай холбогдуулан “Б” талын бүх эрх, үүрэг, хариуцлагыг “А” талд шилжүүлэхтэй холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.
- 1.2 Энэхүү гэрээг байгуулснаар “Б” талын бүх эрх, үүрэг, хариуцлага талуудын хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарснаас хойш 2022 оны тайлант жилийн хоёр дугаар хагас жилээс эхлэн “А” талд бүрэн шилжих буюу “Б” талын аливаа эрх, үүрэг, хариуцлагыг “А” тал дангаар эдэлж, хариуцах болно.
- 1.3 Гэрээний “Б” талыг “А” талд нэгтгэснээр “А” талын хувьцааны тоо хэмжээ болон Хувьцаа эзэмшигчийн эзэмшлийн хувь өөрчлөгдөхгүй хэвээр байх ба “А” талын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ..... / / төгрөг, “А” талын нэгж хувьцааны нэрлэсэн үнэ () төгрөг болно.
- 1.4 Талуудын Хувьцаа эзэмшигчийн Шийдвэр болон энэхүү гэрээг үндэслэн “Б” талын дараах эрх, үүрэг, хариуцлагыг эд хөрөнгийн хамтаар “А” талд шилжүүлэх ажиллагааг талууд хамтран хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 1.4.1 “Б” талын нэр дээр бүртгэлтэй аливаа эдийн болон эдийн бус хөрөнгө, түүнд хамаарах бүх эрх, үүрэг, хариуцлага;
 - 1.4.2 “Б” талын нэр дээр бүртгэлтэй, төрийн байгууллагаас баталсан шийдвэр, гэрээ, гэрчилгээ болон бусад төрлийн бичиг баримтаар олгогдсон эрх, зөвшөөрөл;
 - 1.4.3 “Б” талын гэрээний дагуу болон хуулийн дагуу олгогдсон эрх, хүлээх үүрэг, хариуцлага;
- 1.5 Энэхүү гэрээний 1.4-т заасан шилжүүлэх ажиллагааны хүрээнд дараах үйл ажиллагааг талууд хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 1.5.1 “А” ба “Б” талуудын тус тус нэгтгэлийн өмнөх хаалтын санхүүгийн тайлан балансыг гаргаж, баталгаажуулна.

- 1.5.2 “Б” талыг “А” талд нэгтгэсний дараах “А” талын санхүүгийн тайлан балансыг гаргаж, баталгаажуулна.
- 1.5.3 “Б” талыг “А” талд нэгтгэсний дараа буюу талуудын хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарснаас хойш 2022 оны тайлант жилийн хоёр дугаар хагас жилээс эхлэн “А” тал дангаар санхүүгийн болон татварын тайлан тооцоог гаргаж тайлагнана.
- 1.5.4 “Б” талын нэр дээр бүртгэлтэй эдийн ба эдийн бус хөрөнгийг “А” тал руу шилжүүлэх ажлыг хамтран гүйцэтгэнэ.
- 1.5.5 “Б” тал нь өөрийн өглөг ба авлагын тооцоог харилцагч нартай хийж, тулган баталгаажуулж, гэрээг “А” тал шинэчлэн байгуулна.
- 1.5.6 “Б” талын бүх эрх, үүрэг, хариуцлагыг “А” талд шилжүүлж байгаатай холбоотойгоор талуудын хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарснаас хойш 2022 оны тайлант жилийн хоёр дугаар хагас жилээс эхлэн “Б” талын санхүүгийн бүхий л гүйлгээг “А” талын нэр дээр бүртгэж, гүйцэтгэх ба “Б” талын хариуцан хэрэгжүүлж буй барилгын төслийн аливаа гэрээ, хэлэлцээрийг цаашид “А” тал хариуцаж хийнэ.
- 1.5.7 Энэхүү гэрээний дагуу “Б” тал нь өөрийн бүх эрх, үүрэг хариуцлагаа “А” талд шилжүүлж байгаатай холбоотойгоор талуудын хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарснаас хойш 2022 оны тайлант жилийн хоёр дугаар хагас жилээс эхлэн компанийн дүрэмд заасан үйл ажиллагааг эрхлэхгүй бүрэн зогсоох ба талуудын нэгтгэлийн дараах тайлан баланс баталгаажиж, “А” талын дүрэм шинэчлэн батлагдсаны дараа Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад холбогдох бүртгэлийг хийлгэнэ.
- 1.5.8 Гэрээний “Б” талын дүрэмд заасан үйл ажиллагааг талуудын хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарснаас хойш 2022 оны тайлант жилийн хоёр дугаар хагас жилээс эхлэн “А” тал хэрэгжүүлнэ.
- 1.5.9 “Б” талыг “А” талд нэгтгэхтэй холбоотойгоор бусад шаардлагатай ажиллагааг хийнэ.

Хоёр, Бусад зүйл

- 2.1 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэ гэрээнд нэмэлт болон өөрчлөлт оруулах ба уг нэмэлт, өөрчлөлт нь гагцхүү бичгээр үйлдэгдэж, талуудын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажин хүчин төгөлдөрт тооцогдон энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.
- 2.2 Энэхүү гэрээтэй холбогдон талуудын хооронд аливаа маргаантай асуудал үүсэхгүй болно.
- 2.3 Энэхүү гэрээг 4 хувь үйлдэн талууд гарын үсэг зурж тамгаар баталгаажуулав.

Гэрээ байгуулсан:

“А” талыг төлөөлж:
Гүйцэтгэх захирал

“Б” талыг төлөөлж :
Гүйцэтгэх захирал

“Сүү” ХК-д Макс Агро ХХК-г нэгтгэх журам

1. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү журам нь компанийн тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-л заасны дагуу “Макс Агро” ХХК-г “Сүү” ХК-д нэгтгэх шийдвэр гаргах, нэгтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, нэгтгэх замаар өөрчлөн байгууладсантай холбогдон үүсэх хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх, нэгтгэсэнтэй холбогдон “Макс Агро” ХХК-ийг улсын бүртгэлээс хасуулах, “Сүү” ХК-ийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Энэхүү журам /цаашид журам гэх/ нь “Сүү” ХК /буюу А тал/, “Макс Агро” ХХК /буюу Б тал/ нарын хооронд байгуулсан нэгтгэх гэрээний салшгүй хэсэг болно.

2. Компанийг нэгтгэх зорилго

- 2.1 Нэгтгэж буй компани буюу А талын хувьд:
- 2.1.1 “Сүү” ХК-ийн 100% хөрөнгө оруулалттай охин компани болох Макс Агро ХХК-г нэгтгэн хөдөө аж ахуйн кластер ферм хэлбэрээр хөгжүүлэх.
- 2.2 Нэгдэж буй компани буюу Б талын хувьд:
- 2.2.1 “Сүү” ХК-нд нэгдэн хөдөө аж ахуйн кластер ферм хэлбэрээр хөгжих.
- 2.3 Нэгтгэж буй компанийн саналын эрхтэй хувьцааны хувийг эзэмшигчид нь компани нэгтгэхийг зөвшөөрч, нэгдэж буй компанийн хувьцаа эзэмшигчид ... хувийн саналаар нэгдэхийг дэмжиж, компанийн удирдлагыг “Сүү” ХК хэрэгжүүлэхээр харилцан тохиролцсон нь энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэх гол нөхцөл болж байна.
- 2.4 А талын 20.... оны-р сарын-ний өдрийн балансаар нэгж хувьцааны дансны мөнгө ба хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт бүрэн нийцэж байна.
- 2.5 Дээрх шалтгануудыг үндэслэн “Макс Агро” ХХК-ийг “Сүү” ХК-д нэгтгэх замаар өөрчлөн зохион байгуулах нь зүйтэй гэж харилцан тохиролцов.

3. Өөрчлөн байгуулах нөхцөл

- 3.1 Иргэний хуулийн 31 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 18 болон 20 дугаар зүйл компани нь эрх барим дээд байгууллага болох Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр өөр компанид нэгдэж, өөр компанийг өөртөө нэгтгэх замаар өөрчлөгдөж болох талаар заасан зохицуулалтыг компанийг нэгтгэх үндэслэл болгов.
- 3.2 Макс Агро ХХК-г нэгтгэн хөдөө аж ахуйн кластер ферм хэлбэрээр хөгжүүлэх зорилгоор Компанийг нэгтгэж, компанийг нэгтгэх шийдвэрийг хуульд нийцүүлж гаргах нөхцлийг бүрдүүлж байна.

4. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах

- 4.1 Компанийг нэгтгэх гэрээ болон журмыг А талын компанийн болон Б талын компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар тус тус хэлэлцүүлнэ.
- 4.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хууль, журмын дагуу зарлаж, хувьцаа эзэмшигчдэд энэхүү журмын төсөлтэй танилцах боломжийг олгоно.
- 4.3 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар нэгтгэх гэрээ, журмыг хэлэлцэж, компанийн дүрэм болон холбогдох хуулиулал нийцүүлж шийдвэр гаргана.

5. Өөрчлөн байгуулах журам

- 5.1 Компанийг нэгтгэх ажиллагааг А талын ТУЗ-ийн хурлаас сонгогдсон "Өөрчлөн байгуулах комисс" эрхлэн гүйцэтгэнэ.
- 5.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарснаас хойш нэгтгэх замаар өөрчлөн байгуулахтай холбоотой ажлыг өөрчлөн байгуулах комиссоос хуулийн дагуу явуулж Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж зэрэг байгууллагуудад холбогдох мэдээллийг хүргүүлнэ.
- 5.3 Компанийг нэгтгэх шийдвэр гарснаар компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.1-д заасны дагуу энэ шийдвэрийн талаар эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй А талын хувьцаа эзэмшигчдийн хувьд компаниас хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрх үүснэ.
- 5.4 Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг өөрчлөн байгуулах комиссоос компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу хэрэгжүүлнэ. Үүнд:
- 5.4.1 ХЭХ-аас нэгтгэх шийдвэр гаргаснаас хойш ТУЗ- нь хувьцааг эргүүлэн худалдан авах үнийг тогтоох, энэ талаар олон нийтэд мэдээлэх, хувьцаа эзэмшигчдээс эргүүлэн худалдах хүсэлтээ компанид ирүүлэх эцсийн хугацаа зэргийг тодорхойлсон шийдвэр, хувьцаа эзэмшигчдийн шаардах эрх хэрэгжүүлэх журмыг батална.
- 5.4.2 Шийдвэр гаргаснаас хойш ажлын 30 хоногийн дотор компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.1, 54 дүгээр зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдлийн гаргасан хувьцаагаа эргүүлэн худалдан авах тухай шаардлагыг бүртгэх ажиллагааг гүйцэтгэнэ.
- 5.4.3 Шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 30 өдрийн дотор шаардах эрх хэрэгжүүлэх хүсэлтийг ирүүлээгүй тохиолдолд Хувьцаа эзэмшигчээр хэвээр үлдэх саналтай гэж үзнэ.
- 5.4.4 СЗХ нь нэгтгэх ажиллагааг бүртгэхийг зөвшөөрсөн тухай шийдвэрийг гаргаснаар хувьцаа эзэмшигчдийн шаардах эрхийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.
- 5.4.5 Санхүүгийн зохицуулах хорооноос нэгтгэх зөвшөөрөл гарсны дараа Б талын үйл ажиллагааг Компанийн тухай хуулийн 26-29 дүгээр зүйлд заасны дагуу А тал хариуцан явуулна.

6. Нэгдэж буй компанийн хувьцааг нэгтгэж буй компанийн хувьцаанд хөрвүүлэх журам, тооцоо

- 6.1 Талуудыг нэгтгэхдээ тал тус бүхийн 2021 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайланг үндэслэнэ.
- 6.2 Нэгтгэж байгаа "Сүү" ХК болон нэгдэж байгаа "Макс Агро" ХХК-ийн 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн баланс дараах байдалтай байна. Үүнд:

"Сүү" ХК-ийн баланс /сая төгрөг/

	2020	2021
ХӨРӨНГӨ		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		
Авлага		
Үндсэн хөрөнгө		
Хөрөнгө оруулалт, санхүүгийн хөрөнгө		
бусад		
ӨМЧ БА ТӨЛБӨР		
Хувьцаат капитал		
Нэмж төлсөн капитал		

Хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөц		
Хуримтлагдсан ашиг/алдагдал		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөр		

“Макс Агро” ХХК-ийн баланс /сая төгрөг/

	2020	2021
ХӨРӨНГӨ		
Мөнгө ба түүнтэй адиртгах хөрөнгө		
Авлага		
Үндсэн хөрөнгө		
Хөрөнгө оруулалт, санхүүгийн хөрөнгө		
бусад		
ӨМЧ БА ТӨЛБӨР		
Хувьцаат капитал		
Нэмж төлсөн капитал		
Хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөц		
Хуримтлагдсан ашиг/алдагдал		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөр		

6.3 Тал тус бүр доор дурдсан үнэлгээг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд уг үнэлгээнд үндэслэн, нэгдэж байгаа компанийн хувьцааг нэгтгэж байгаа компанийн хувьцаанд хөрвүүлнэ.

Үзүүлэлт	“Сүү” ХК	“Макс Агро” ХХК	Нэгдсэн дүн
Хувьцааны тоо			
Нэгжийн үнэ			
Халаасны хувьцаа			
Хувь нийлүүлсэн хөрөнгө			
Нэгжийн үнэ			
Халаасны хувьцааны үнийн дүн			
Нийт хөрөнгө /цэвэршүүлсэн дүн/			
Өр төлбөр /цэвэршүүлсэн дүн/			
Эздийн өмч /цэвэршүүлсэн дүн/			

6.4 Нэгтгэсний дараа “Сүү” ХК нь нэг бүр нь төгрөгийн үнэтэй ширхэг хувьцаатай хэвээр үлдэнэ.

6.5 “Макс Агро” ХХК-ийн “Сүү” ХК-д нэгтгэснээр “Сүү” ХК-ийн эздийн өмчид өөрчлөлт орохгүй ба “Макс Агро” ХХК-ийн нэгтгэсний дараа нэгж хувьцааны дансны үнэ төгрөг хэвээр байна.

7. Нэгтгэх үйл ажиллагааг дуусгах

7.1 Нэгтгэсэн компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр гарсны дараа нэгдэж буй компанийг татан буулгаж, улсын бүртгүүлснээр.

- 7.2 Компанийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д заасны дагуу компанийг өөрчлөн байгуулах үйл ажиллагаа дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор "Сүү" ХК болон "Макс Агро" ХХК нь дараах мэдэгдлийг зээлдүүлэгч болон харилцагчиддаа тус тус бичгээр хүргүүлнэ. Үүнд:
- 7.2.1 Компани өөрчлөн байгуулагдсан тухай /он, сар, өдөр, өөрчлөн байгуулсан арга, хэлбэр, шийдвэр/
 - 7.2.2 Компанийг нэгтгэсний улмаас компанийн нэр, хаяг, байршил, санхүүгийн байдалд гарсан өөрчлөлт
 - 7.2.3 "Макс Агро" ХХК-ийн зээлдүүлэгчид болон бусад харилцагчдын өмнө хүлээх эрх, үүрэг, "Сүү" ХК-д шилжсэн тухай.

8. Хариуцлага

- 8.1 Энэхүү журамд заасан өөрчлөн байгуулах үйл ажиллагааг хоёр компаниас томилогдсон өөрчлөн байгуулах комисс хариуцан гүйцэтгэнэ.
- 8.2 Өөрчлөн байгуулах үйл ажиллагааг хариуцах комиссыг "Сүү" ХК-ийн ТУЗ-өөс томилох ба тухайн ажлыг хууль журам, энэхүү журам болон гэрээнд заасны дагуу, хугацаанд хэрэгжүүлээгүйгээс харилцагчид болон хувьцаа эзэмшигчдэд хохирол учруулсан бол хохирлыг комиссыг хариуцан барагдуулахаар тогтоосон байна.
- 8.3 Санхүүгийн зохицуулах хороо болон бусад эрх бүхий байгууллагаас захиргааны хариуцлага оногдуулсан бол "Сүү" ХК хариуцан барагдуулна.

9. Компанид хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрх,

- 9.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах шийдвэр гарсантай холбогдуулан Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.1, 53.1.2-д заасны дагуу хувьцаа эзэмшигч нь компанид хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрх үүснэ.
- 9.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас нэгтгэх шийдвэрийг гарсан өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд компанид хувьцаагаа эргүүлэн худалдах шаардах эрх үүссэн гэж үзэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоогүй, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон ч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид нь компаниас хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах хувьцаагаа компанид худалдах эрхтэй.
- 9.3 Компани хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гаргасан өдрөөс хойш ажлын 30 өдрийн дотор хувьцаагаа эргүүлэн худалдан авах шаардлагыг компани дээр бичгээр хүлээн авна.
- 9.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 30 хоногийн дотор шаардах эрх хэрэгжүүлэх хүсэлтийг ирүүлээгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчээр хэвээр үлдэх саналтай гэж үзнэ.